

## 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийх ажлуудын төлөвлөгөөг Эрчим хүчний Сайдын 2023 оны 01-ээр сарын 09-ний өдрийн А/05 дугаар тоот тушаалаар баталсан.

Үндсэн тоноглолын их засварын “ТГ№3 статорын ороомог болон өдөөгчид их засвар хийх” ажилд 758.48 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд гадны байгууллагаар генераторын төлөв байдлыг тодорхойлох 12 төрлийн хэмжилт, туршилтын ажлыг хийлгэхэд 2.9 жил ашиглагдах дүгнэлт гарсан тул хойшлуулсантай холбоотойгоор Эрчим хүчний сайдын 2023 оны 11 сарын 17-ны өдрийн А/251 тоот тушаалаар 2023 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг шинэчлэн баталсан.

### Батлагдсан зорилтот түвшингийн биелэлтийг харьцуулахад:


Д/д	Үзүүлэлтүүд	х.н	2022 он гүйцэтгэл	2023 он		Зөрүү дүн		
				Төл	Гүйц	Өмнөх оноос	Төл- өөс	
1	Боловсруулсан ЦЭХ	сая.квтц	155.7	152.6	152.4	(3.3)	(0.2)	
2	ДХЦЭХ	Биетээр	сая.квтц	19.1	219.3	18.97	(0.1)	(200.3)
		Хувиар	хувь	12.3%	12.70%	12.4%	0.0	(0.0)
3	Эрчим хүч түгээлт Цахилгаан	сая.квтц	136.6	133.2	133.4	(3.2)	0.2	
	Дулаан	мян.Гкал	241.1	219.3	264.0	22.9	44.7	
4	Нийт орлого	сая.төг	26,384.4	32,419.7	34,499.5	8,115.1	2,079.8	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	26,045.3	32,169.7	34,138.5	8,093.2	1,968.8	
5	Нийт зардал	сая.төг	28,372.5	36,433.9	34,488.8	6,116.3	(1,945.1)	
	Үүнээс: Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	267.7	184.3	170.5	(97.2)	(13.8)	
6	Ашиг / алдагдал /	сая.төг	-1,988.1	-4,014.2	10.70	1,998.8	4,024.9	
	Цэвэр ашиг / алдагдал /	сая.төг	-1,988.1	-4,014.2	7.35	1,995.5	4,021.6	
7	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	1.1	1.1	1.0	(0.1)	(0.1)	
8	Авлага	сая.төг	1,685.0	1,390.0	1,280.3	(404.7)	(109.7)	
9	Өглөг	сая.төг	1,308.2	1,355.6	1,839.1	530.9	483.5	
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	910.7	1,000.0	1,483.5	572.8	483.5	
10	ХО, ИЗ, ТЗБАХ-ний зардал	сая.төг	2,032.6	2,771.6	2,609.7	577.1	(161.9)	
11	Жишмэл түлшний зарцуулалт	гр/квтц	596.8	620.1	596.2	(0.6)	(23.9)	
	ЦЭХ	кг/Гкал	197.6	201.1	197.3	(0.2)	(3.8)	
12	Нийт ажиллагсдын тоо	тоо	288	311	280	(8.0)	(31.0)	
13	Нийт цалингийн сан	сая.төг	8,562.8	11,074.1	10,295.2	1,732.4	(778.9)	

## 1. Цахилгаан эрчим хүч:

ЦЭХ 2023 оны гүйцэтгэлээр 152.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 18.9 сая кВт.ц буюу 12.45 хувийг нь зарцуулан 133.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч түгээж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 100.1 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

ДХЦЭХ: 2023 оны гүйцэтгэлээр нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 12.45 хувь буюу 18.97 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэрэгцээндээ зарцуулсан нь төлөвлөгөөнөөс 390 мян кВт.ц буюу 0.24 хувиар буурсан байна.


ЦЭХ-ний түгээлтийн төлөвлөгөө 8,9,10-р саруудад тасарсан харагдаж байна. Энэ нь ТГ№3-н их засварын ажил 5 сарын 20-оос 8 сарын 7-ны хооронд төлөвлөсөн боловч гүйцэтгэх компаниас хамаарч хугацаа хойшлогдсоноор 8,9,10-р сарууд буюу төлөвлөгдөөгүй саруудад хийгдсэн. ТГ№3-н их засварын нэмэлт ажлууд гарч ирснээр хугацаа хойшлогдож 10 сарын 21-нд хэвийн ажиллагаанд орж ажилласан.



## 2. Дулааны эрчим хүч:

Тайлант онд усаар 201,173 Гкал, Уураар 62,864 Гкал, Нийт 264,037 Гкал Дэх түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 20,497 Гкал илүү түгээж төлөвлөгөөний биелэлт 109.5% байна. Диспетчерийн графикийн зөрчилгүй ГОТ 100% биелсэн байна. Өмнөх рны мөн үеийн гүйцэтгэлээс 22,897 Гкал илүү түгээж 109.5% биелэлттэй байна.

Дулааны түгээлтийн бүтцийг харуулбал: Нийт дулааны түгээлтийн 73.2 хувийг буюу 193285 Гкал-ыг УБДС ХК, коллектороос 3 хувь буюу 7888 Гкал, уураар 23.8 хувь буюу 62864 Гкал тус тус түгээсэн байна. Жил ирэх тусам уурын түгээлтийн хувь нэмэгдэж байна.



## 2. Жишмэл түлшний хувийн зарцуулалт:

Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2023 оны байгаа гүйцэтгэлээр ЦЭХ-нд 596.23 гр/кВт.ц гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 0.6 гр/кВт.ц-аар, төлөвлөсөн хэмжээнээс 23.9 гр/кВт.ц-аар тус тус хэмнэж, дулаанд 197.33 кг/Гкал гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 0.2 кг/Гкал-аар, төлөвлөгөөнөөс 4.5 кг/Гкал-аар тус тус буурч нийлбэр дүнгээр 120.6 тн жишмэл түлш хэмнэсэн буюу бодит нүүрсээр 4438 тн хэмнэсэн байна.

Түлшний хувийн зарцуулалт хэмнэсэн шалтгаан нь:

- Конденсатын алдагдал 0.1 %-иар буурсан
- Турбины даралт 0.3 ата, температур 0.6 градусаар нэмэгдсэн
- Зуухны даралт 0.2 ата, температур 0.5 градусаар нэмэгдсэн бөгөөд зуухны ажилласан цаг 95 цагаар буурсан.
- Вакум 3%-иар нэмэгдсэн.
- Нүүрсний дулаан гаргах чадвар төлөвлөсөн хэмжээнээс 54 ккал/кг-аар нэмэгдсэн.

## 3. Нийт орлого:

Тайлангийн хугацаанд: Цахилгаан эрчим хүчний орлого 30,485.2 сая.төг, Дулааны эрчим хүчний орлого 3,653.32 сая.төг, Үйл ажиллагааны бус орлого 360.9 сая.төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт орлогын дүн **34,499.5** сая.төг байна. Нийт борлуулалтын орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 1,521.4 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 89.3 хувийг ЦЭХ-ний, 10.7 хувийг ДЭХ-ний орлого эзэлж байна.

2023 онд үйл ажиллагааны бус орлогоор 250.0 сая төг олохоор төлөвлөн **360.9** сая төгрөг олж төлөвлөгөөг 110.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Үйл ажиллагааны бус орлого:

Д/д	Үзүүлэлт	ҮАБО	Эзлэх хувь
1	Хүүгийн орлого	26,552,356	7%
2	Торгуулийн орлого	44,816,808	12%
3	Бусад үйл ажиллагааны бус орлого	122,587,247	34%
4	Пүү	39,444,000	11%
5	Мөнгө тэмдэгт устгал	9,087,545	3%
6	Түрээс	29,476,000	8%
7	Тендерийн материал	3,436,364	1%
8	Буцаагүй конденсат	85,515,192	24%
Нийт дүн		360,915,511	100%

## 5. Нийт зардал:

Тайлангийн хугацаанд: **36,433.9** сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр **34,488.8** сая төгрөгийн зардал гарган, төлөвлөгөөнөөс **1,945.1** сая төгрөгөөр хэмнэсэн байна. Нийт зардлын 41 хувийг түлшний зардал, 29 хувийг цалингийн зардал, 11 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 19 хувийг бусад тогтмол зардал эзэлсэн байна.

Зардлын задаргаа:

Зардлын төрөл	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/
Түлшний зардал	14,712.20	14,072.00	-640.17
Шатахууны зардал	404.68	225.2	-179.48
Урсгал засвар	610.61	531.1	-79.51
Үндсэн ба нэмэгдэл цалин	10,957.33	10,162.10	-795.23
Бусад зардлууд	3,994.10	3,947.70	-46.45
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	3,673.46	3,857.50	184.06
Ажиллагсдын нийгмийн зардал	1,897.29	1,522.70	-374.6
Үйл ажиллагааны бус зардал	184.25	170.5	-13.74
<b>Нийт дүн</b>	<b>36,433.92</b>	<b>34,488.50</b>	<b>-1,945.11</b>

## 6. Ашиг, алдагдал:

ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 180 төгрөг ба 1 кВт.ц ЦЭХ-ийг дунджаар 228.5 төгрөгөөр борлуулж, нэгжээс 48.4 төгрөгийн ашигтай ажиллаж байна.

ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 38,992.6 төгрөг ба 1 Гкал ДЭХ-ийг дунджаар 13,836.4 төгрөгөөр борлуулж, нэгжээс 25,156.2 төгрөгийн алдагдалтай ажиллаж байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өссөн дүнгээр		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Үйл ажиллагааны ашиг алдагдал</b>				
Нийт орлого	сая.төг	32,169.70	34,138.50	2,111.13
Нийт зардал	сая.төг	36,249.60	34,318.30	-2,148.57
Ашиг, алдагдал	сая.төг	-4,079.90	<b>-179.8</b>	3,900.20
<b>Үйл ажиллагааны бус ашиг алдагдал</b>				
Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	250	361	111.3
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	184.3	170.5	-13.8
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая.төг	65.7	<b>190.5</b>	124.7

2023 онд **7.4** сая төгрөгийн ашигтай гарсан бөгөөд батлагдсан төлөвлөгөөнөөс **4,021.5** сая төгрөгөөр алдагдлыг бууруулсан байна.

## 7. Их засвар, Хөрөнгө оруулалт, ТЗБАХ

- Үндсэн ба туслах тоноглолын их засвар:

Нийт 14 туслах тоноглолын их засварыг хийхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувь буюу 14 тоноглолын их засварыг хийж гүйцэтгсэн байна. Туслах тоноглолын их засварт 513,730 мян.төг зарцуулахаар төлөвлөснөөс 439,328 мян.төг зарцуулсан ба Тэжээлийн усны шугамын их засвараас 10,989.1 мян.төг, Төв агуулахын засвараас 20,331.4 мян.төг, Үндсэн бойлерын их засвараас 7,370 мян.төг, 2-р шатны фильтрийн засвараас 7,200.0 мян.төг, Нийт туслах тоноглолын төлөвлөсөн зардлаас 75,401.9 мян.төг хэмнэсэн байна.

- ТЗБАХ:

ТЗБАХ-ний хүрээнд 6 ажлыг 621,220.0 мянган төгрөгөөр хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба Түлшний бак, шугам хоолойг шилжүүлэн шинээр барих, Брызгаль №3-ын бетоныг хүчитгэх, ТГ№1-ийн конденсаторын гуулин хоолойг солих, Үнсэн сангийн гадаргууг хөрсжүүлэх, Газардуулгын байгууламжийг хийх зэрэг ажлуудыг 617,432.7 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэв.

- Хөрөнгө оруулалт:

Хөрөнгө оруулалтаар 19 төрлийн 593,026.1 мянган төгрөгийн худалдан авалт төлөвлөснөөс 19 нэр төрлийн хөрөнгийг 486,386.7 мянган төгрөгөөр худалдан авсан ба 106,639.4 төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /%/
1	Үндсэн болон туслах тоноглолын их засвар	15	15	100
2	ТЗБАХ	6	6	100
3	Хөрөнгө оруулалт	19	19	100
	<b>Нийт</b>	<b>40</b>	<b>40</b>	<b>100</b>

## 8. Авлага:

Нийт авлага 1,280.0 сая төгрөг, үүнээс “ДҮТ” ХК-иас авах авлагын үлдэгдэл 340.5 сая төгрөг болж оны эхнээс 1,131.3 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс **110** сая төгрөгөөр бууруулан ажилласан байна.

Авлагын төрөл	2022 оны гүйцэтгэл сая.төг	2023 оны төл сая.төг	2023 оны гүйцэтгэл сая.төг	Өөрчлөлт	
				ӨН.ОНООС	ТӨЛ-С
ДҮТ ХК	1,471.80		340.5	-1,131.30	
УБДС ХК	39.3	-	33.7	-5.6	-
Бусад авлага	213.2	-	905.8	692.6	
<b>Нийт авлага</b>	<b>1,685.00</b>	<b>1,390.00</b>	<b>1,280.00</b>	<b>-405</b>	<b>-110</b>

## 9. Өглөг:

Нийт өглөг 1,839.0 сая төгрөг, үүнээс богино хугацаат өглөг 1,438.4 сая төгрөг болж оны эхнээс 572.8 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс **483.4** сая төгрөгөөр өссөн байна.

Өглөгийн төрөл	2022 оны гүйцэтгэл сая.төг	2023 оны төл сая.төг	2023 оны гүйцэтгэл сая.төг	Өөрчлөлт	
				Өн оноос	Төл-с
Багануур ХК	-	-	-	-	-
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг	910.6	1,000.00	1,329.70	419.1	329.7
Татварын өглөг	-	-	153.7	153.7	153.7
БХӨТ-ийн дүн	910.6	1000	1,483.40	572.8	483.4
УХЗээл, зээлийн хүү	397.5	355.6	355.6	-41.9	-
Нийт өр төлбөрийн дүн	1,308.10	1,355.60	1,839.00	530.9	483.4